

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО ДЭМЖСЭН**

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 60.5, 60.6, 60.7 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн" гэсний дараа "орон нутгийн" гэж, мөн зүйлийн 60.5, 60.6, төслийн 2 дугаар зүйлийн 59.2 дахь хэсгийн "сум, дүүргийн" гэсний дараа "орон нутгийн" гэж тус тус нэмэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын  
гишүүн Б.Болор**

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 60.7 дахь хэсгийн "ашигт малтмал ашигласан" гэсний дараа "аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд" гэж нэмэх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын  
гишүүн Б.Болор**

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 60.8 дахь хэсгийн "Засгийн газар тогтооно" гэснийг "Засгийн газар батална" гэж өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын  
гишүүн Б.Болор**

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 60.6 дахь хэсгийн "орших" гэснийг "байрших" гэж, 60.7 дахь хэсгийн "тусгай зөвшөөрлийн талбай байрлах" гэснийг "ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших" гэж тус тус өөрчлөх;

**Санал гаргасан: Улсын Их Хурлын  
гишүүн Б.Болор**